



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Цогт-Очирын АНАНДБАЗАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-22-13, Факс: 32-70-16  
E-mail: anandbazarts@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023.01.03 № УХГ-03/31

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Улсын Их Хурлын тогтоолын төсөл Т  
өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгнө үү.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбоотой материалыг хавсаргав.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Ц.АНАНДБАЗАР

Б.БАТТӨМӨР

Н.НАРАНБААТАР

Ш.РАДНААСЭД

Ц.СЭРГЭЛЭН

А.АДЬЯАСҮРЭН

Д.БАТ-ЭРДЭНЭ

2023000012



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Цогт-Очирын АНАНДБАЗАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-22-13, Факс: 32-70-16  
E-mail: anandbazarts@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023.01.03 № УХ-03/30

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

ЦАНАНДБАЗАР

2023.01.03



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Цогт-Очирын АНАНДБАЗАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-22-13, Факс: 32-70-16  
E-mail: anandbazarts@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023. 01. 03 № ЧИТ-03/19  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд санал өгнө үү.

Холбогдох материалыг хавсаргав.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Ц.АНАНДБАЗАР

Б.БАТТӨМӨР

Н.НАРАНБААТАР

Ш.РАДНААСЭД

Ц.СЭРГЭЛЭН

А.АДЬЯАСҮРЭН

Д.БАТ-ЭРДЭНЭ

2023000015

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦААГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЭХ,  
ИРГЭДИЙН ХЯНАЛТАД ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлэй, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх” гэж, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан ““АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.2.19-д “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.” гэж тус тус заасан нь тогтоолын төслийн боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд Улсын Их Хурлын бусад шийдвэр тогтоолын хэлбэртэй байна” гэж заасныг үндэслэн тогтоолын төслийг боловсрууллаа.

Практик үндэслэл, шаардлага

“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоол, 2012 оны 116 дугаар тогтоолуудаар иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

**2012 оны 116 дугаар тогтоолоор иргэн бүрд 1.5 сая төгрөг олгох арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоолын дагуу хувьцаа эзэмшиж байгаа иргэдэд 536 ширхэг хувьцааг нэмж эзэмшүүлэх, 2011 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр болон түүнээс өмнө шинээр төрсөн иргэнд 1072 ширхэг хувьцааг эзэмшүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, “ҮЦТТХХТ” ХХК-ийн гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасан. Тус тогтоолын дагуу “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК /хуучнаар/ нь иргэдийн бүртгэлийг баталгаажуулан дуусч, иргэдэд үнэт цаасны данс нээсэн боловч тус компанийтай “Эрдэнэс Тавантолгой” ХК нь холбогдох журмын дагуу үнэт цаас хадгалуулах гэрээг өнөөг хүртэл байгуулаагүй байна.**

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 116 дугаар тогтоолоор “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 20 хүртэлх хувийг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр болон түүнээс өмнө шинээр төрсөн иргэнд бүрт 1072 ширхэг хувьцааг эзэмшүүлэхээр шийдвэрлэж, мөн оны 181 дүгээр тогтоолоор 1072 хувьцааг 1.0 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр үнэлж тооцсон.

Мөн Улсын Их Хурлын 2011 оны 53 дугаар тогтоолын дагуу Хүний хөгжил сангаас хишиг, хувийг бэлэн мөнгөөр авах хүсэлт гаргасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 2010-2011, 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртсэн оюутан, 2011 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр хишиг, хувь хэлбэрээр нийт 461.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Тус компанийн хувьцаа эзэмшлийн бүртгэл 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа эзэмшигч тоо	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь %/
Аж ахуйн нэгж	486	7,065,038	0.06%
Монгол Улсын иргэн	2,512,771	2,213,063,202	18.44%
“Эрдэнэс Монгол” ХХК	1	9,779,871,760	81.50%
Нийт гаргасан хувьцаа		<b>12,000,000,000</b>	<b>100.0%</b>

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 181 дүгээр тогтоолын 3 дугаар заалтад хоёрдогч зах зээлийн арилжааг эхлэх хүртэлх хугацаанд “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгөөр иргэдэд эзэмшүүлэхээр заасан.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд иргэдээс “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн хувьцааг Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдах хүсэлт гаргасан тул тус байнгын хорооны 2015 оны 05 дугаар тогтоолоор төлбөр төлөгдөөгүй буюу хишиг, хувь хүртээгүй иргэдийн хувьцааг буцаан эзэмшүүлэх, хөрөнгийн болон хувьцааны бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн цэгцэлж, нийт хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжид эзэмшлийн хувьцааг нь баталгаажуулах арга хэмжээ авах чиглэлийг өгч байсан байна.

Дээрх чиглэлийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 151 дүгээр тогтоолоор Засгийн газарт нэрлэсэн үнээр худалдах хүсэлт гаргасан боловч хувьцааны төлбөр авч чадаагүй буюу хишиг, хувь хүртээгүй иргэдэд хувьцааг нь буцаан эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцаа нь Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлээгүй учир иргэд хувьцаагаа нээлттэй арилжаалах, хувьцаа эзэмшигчийн бусад эрх үүргээ хэрэгжүүлэх, хувьцаагаа арилжаалах, бэлэглэх, өвлүүлэх нөхцөл одоог хүртэл бүрдээгүй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшдэг иргэдийн мэдээллийг иргэдийн овог, нэр, регистрийн дугаараар, нас барсан болон харьяатаас гарсан, шинээр төрсөн хүүхдийн тоогоор гаргасан байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас хаяг тодорхойгүй 56 801 иргэн,
- регистрийн дугаар солигдсон 22 972 иргэний мэдээлэл бүртгэгджээ.

Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын 2,512,771 иргэн, 486 аж ахуйн нэгж эзэмшиж байгаа бөгөөд нас барсан 90,284, харьяатаас гарсан 13,365 иргэн байна.

Одоогийн байдлаар Монгол Улсад “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмших эрхтэй 3,306,052 иргэн байна.

Цаашид компанийн сайн засаглалыг хөгжүүлэх, өмчлөл, удирдлагын хяналтын тэнцвэртэй байдлыг хангах, компанийн хувьцааны эзэмшил, мэдээллийн ил тод, нээлттэй байдлаар дамжуулан олон нийтийн хяналтыг бий болгож, зах зээлд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг Компанийн тухай хуулийн 3.7-д заасан нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байна.

Мөн сүүлийн үед үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг иргэдийн хяналтад оруулах, иргэдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хэмжээг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авах шаардлага үүсч байна.

Түүнчлэн 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төрсөн Монгол Улсын иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг эзэмшдэггүй тул төрийн эзэмшлийн хувьцаанаас шинээр эзэмшүүлэх болон Монгол Улсын иргэн бүрт хувь тэнцүүлэн нэмж эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж байгалийн баялгаас иргэн бүр тэгш хүртэх боломжийг олгох талаар тогтоолын төсөлд тусгалaa.

### **Хоёр. Тогтоолын төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Тогтоолын төсөл 3 заалт, 3 дэд заалттай байна. Төсөлд “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшээгүй иргэдэд шинээр эзэмшүүлэх, Монгол Улсын иргэн бүрт хувь тэнцүүлэн нэмж эзэмшүүлэх болон тус компанийг нээлттэй

хувьцаат компани болгох бэлтгэл ажлыг хангуулах арга хэмжээний талаар тус тус тусгасан.

**Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагаврын талаар:**

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт дараах эерэг нөлөө үзүүлнэ гэж тооцсон болно:

- Монгол Улсын иргэн бүр байгалийн баялгаас тэгш хүртэх боломж бүрдэнэ.
- Компанийн засаглал сайжирч, өмчлөл, удирдлагын хяналтын тэнцвэртэй байдал хангагдаж, иргэд олон нийтийн хяналтыг бий болгоно

**Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай**

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуультай нийцсэн болно.

--Оо--

**“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦААГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЭХ,  
ИРГЭДИЙН ХЯНАЛТАД ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоол, 2012 оны 116 дугаар тогтоолуудаар иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

**2012 оны 116 дугаар тогтоолоор** иргэн бүрд 1.5 сая төгрөг олгох арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоолын дагуу хувьцаа эзэмшиж байгаа иргэдэд 536 ширхэг хувьцааг нэмж эзэмшүүлэх, 2011 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр болон түүнээс өмнө шинээр төрсөн иргэнд 1072 ширхэг хувьцааг эзэмшүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, “ҮЦТТХТ” ХХК-ийн гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасан. Тус тогтоолын дагуу “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” нь иргэдийн бүртгэлийг баталгаажуулан дуусч, иргэдэд үнэт цаасны данс нээсэн боловч “Эрдэнэс Тавантолгой” ХК нь тус байгууллагаас тогтоосон журмын дагуу үнэт цаас хадгуулах гэрээг өнөөг хүртэл байгуулаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 116 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 20 хүртэлх хувийг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр болон түүнээс өмнө шинээр төрсөн иргэнд бүрт 1072 ширхэг хувьцааг эзэмшүүлэхээр шийдвэрлэж, мөн оны 181 дүгээр тогтоолоор 1072 хувьцааг 1.0 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр үнэлж тооцсон.

Мөн Улсын Их Хурлын 2011 оны 53 дугаар тогтоолын дагуу Хүний хөгжил сангаас хишиг, хувийг бэлэн мөнгөөр авах хүсэлт гаргасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 2010-2011, 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртсэн оюутан, 2011 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр хишиг, хувь хэлбэрээр нийт 461.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Тус компанийн хувьцаа эзэмшлийн бүртгэл 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа эзэмшигч тоо	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь %/
Аж ахуйн нэгж	486	7,065,038	0.06%
Монгол Улсын иргэн	2,512,771	2,213,063,202	18.44%
“Эрдэнэс Монгол” ХХК	1	9,779,871,760	81.50%
Нийт гаргасан хувьцаа		<b>12,000,000,000</b>	<b>100.0%</b>

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 181 дүгээр тогтоолын 3 дугаар заалтад хоёрдогч зах зээлийн арилжааг эхлэх хүртэлх хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгөөр иргэдэд эзэмшүүлэхээр заасан.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд иргэдээс “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн хувьцааг Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдах хүсэлт гаргасан тул тус байнгын хорооны 2015 оны 05 дугаар тогтоолоор төлбөр төлөгдөөгүй буюу хишиг, хувь хүртээгүй иргэдийн хувьцааг буцаан эзэмшүүлэх, хөрөнгийн болон хувьцааны бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн цэгцэлж, нийт хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжид эзэмшлийн хувьцааг нь баталгаажуулах арга хэмжээ авах чиглэлийг өгч байсан.

Дээрх чиглэлийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 151 дүгээр тогтоолоор Засгийн газарт нэрлэсэн үнээр худалдах хүсэлт гаргасан боловч хувьцааны төлбөр авч чадаагүй буюу хишиг, хувь хүртээгүй иргэдэд хувьцааг нь буцаан эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа нь Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлээгүй учир иргэд хувьцаагаа нээлттэй арилжаалах, хувьцаа эзэмшигчийн бусад эрх үүргээ хэрэгжүүлэх, хувьцаагаа арилжаалах, бэлэглэх, өвлүүлэх нөхцөл одоог хүртэл бүрдээгүй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшдэг иргэдийн мэдээллийг иргэдийн овог, нэр, регистрийн дугаараар, нас барсан болон харьяатаас гарсан, шинээр төрсөн хүүхдийн тоогоор гаргасан байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас хаяг тодорхойгүй 56 801 иргэн,
- Регистрийн дугаар солигдсон 22 972 иргэний мэдээлэл бүртгэгджээ.

Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын 2,512,771 иргэн, 486 аж ахуйн нэгж эзэмшиж байгаа бөгөөд нас барсан 90,284, харьяатаас гарсан 13,365 иргэн байна.

Одоогийн байдлаар Монгол Улсад “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмших эрхтэй 3,306,052 иргэн байна.

Цаашид компанийн сайн засаглалыг хөгжүүлж, хувьцааны эзэмшил, мэдээллийн ил тод, нээлттэй байдлаар дамжуулан өмчлөл, удирдлагын хяналтын тэнцвэртэй байдлыг хангаж, олон нийтийн хяналтыг бий болгох, зах зээлд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг Компанийн тухай хуулийн 3.7-д заасан нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байна.

Мөн сүүлийн үед үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг иргэдийн хяналтад оруулах, иргэдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хэмжээг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авах шаардлага үүсч байна.

Түүнчлэн 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төрсөн Монгол Улсын иргэний шинэчилсэн бүртгэлтэй

иргэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг эзэмшдэггүй тул төрийн эзэмшлийн хувьцаанаас 40 хүртлэх хувийг шинээр эзэмшигүүлэх болон Монгол Улсын иргэн бүрт хувь тэнцүүлэн нэмж эзэмшигүүлэх ажлыг зохион байгуулж байгалийн баялгаас иргэн бүр тэгш хүртэх боломжийг олгох талаар тогтоолын төсөлд тусгалаа.

### ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... дүгээр  
сарын .... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн сайн засаглалыг хөгжүүлэх, өмчлөл, удирдлагын хяналтын тэнцвэртэй байдлыг хангах, компанийн хувьцааны эзэмшил, мэдээллийн ил тод, нээлттэй байдлаар дамжуулан олон нийтийн хяналтыг бий болгож, зах зээлд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэнд эзэмшүүлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт гаргасан хувьцааны төрийн эзэмшлийн хувьцаанаас 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төрсөн Монгол улсын иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрт 1072 ширхэг хувьцааг шинээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ Энэ тогтоолын 1.1 дэх дэд заалтад заасны дагуу иргэнд хувьцаа эзэмшүүлсний дараа “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нийт гаргасан хувьцааны төрийн эзэмшлийн хувьцаанаас 40 хүртэлх хувийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол улсын иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрт хувь тэнцүүлэн нэмж эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах;

3/“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг Компанийн тухай хуулийн 3.7-д заасан нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг ханггуулж, төрийн болон иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах;

4/“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд энэхүү тогтоолын 1, 2 дахь дэд заалтад заасан хувьцааг саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлэх;

5/“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэг бүхий төр, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн Хяналтын зөвлөлийг байгуулах, зөвлөлийн бүрэлдэхүүний 40-өөс доошгүй хувийг олон нийтийн төлөөлөл байхаар тогтоох.

6/энэ тогтоолын 5 дахь дэд заалтад заасан Хяналтын зөвлөлд иргэдийг нээлттэй сонгон шалгаруулж томилох.

2.Засгийн газар болон холбогдох байгууллагыг энэ тогтоолын 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн застийн байнгын хорооны дарга /Ц.Цэрэнпүнцаг/-д даалгасугай.

Гарын үсэг

**“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦААГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЭХ,  
ИРГЭДИЙН ХЯНАЛТАД ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2023 он**

## **АГУУЛГА**

**НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....**

**ХОЁР.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНЭСЛЭЛ.....**

**ГУРАВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ  
ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ.....**

- 3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалт.....
- 3.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт.....
- 3.3."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх тогтоолын төслийн зохицуулалт.....
- 3.4."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх тогтоолын төслийн зохицуулалт.....

**ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ  
ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ.....**

- 4.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
- 4.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
- 4.3."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
- 4.4."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

**ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....**

- 5.1.Үнэлэлт, дүгнэлт.....
- 5.2.Зөвлөмж.....

**“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦААГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЭХ,  
ИРГЭДИЙН ХЯНАЛТАД ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ  
ТАЙЛАН**

**НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу компанийн сайн засаглалыг хөгжүүлэх, өмчлөл, удирдлагын хяналтын тэнцвэртэй байдлыг хангах, компанийн хувьцааны эзэмшил, мэдээллийн ил тод, нээлттэй байдлаар дамжуулан олон нийтийн хяналтыг бий болгож, зах зээлд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, тогтоолын заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулахад дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийсэн. Үүнд:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Тогтоолын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл 3 зүйл, 3 дэд заалтаас бүрдэнэ.

**ХОЁР.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаа, үр нөлөөг үнэлж, дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал;
- Практикт хэрэгжих боломж;
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- Харилцан уялдаа зэрэг болно.

1.“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлт нь Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдана.

2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлт нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслөөр бий болгож байгаа зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтооно.

3.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлт нь тогтоолын төслийн заалтыг дагаж мөрдөх субъект хүлээн зөвшөөрөх боломжтой.

4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлт нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, иргэдийн хяналтад оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн заалт, дэд заалт бусад хүчин төгөлдөр хууль, тогтоомжтой нийцсэн эсэхийг үнэлнэ.

## 2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоол, 2012 оны 116 дугаар тогтоолуудаар иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

“Эрдэнэс Тавантолгой” ХК үүсгэн байгуулагдахаа 15.0 тэрбум ширхэг энгийн хувьцаатай байхаар дүрэмдээ зааж өгсөн байна. Монгол Улсын Засгийн газар 2012 онд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 20 хувь болох гурван тэрбум ширхэг хувьцааг иргэн бүрт хуваарилсан билээ. Ингэснээр нэг иргэнд 1072 ширхэг хувьцаа ногдсон юм. Түүнчлэн тухайн үед Засгийн газраас 1072 ширхэг хувьцааг нэг сая төгрөг буюу нэг ширхэг хувьцааны нэрлэсэн үнийг 933 орчим төгрөгөөр үнэлж тооцсон.

Улсын Их Хурлын 2011 оны 53 дугаар тогтоолын дагуу Хүний хөгжил сангаас хишиг, хувийг бэлэн мөнгөөр авах хүсэлт гаргасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 2010-2011, 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртсэн оюутан, 2011 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр хишиг, хувь хүртсэн иргэдэд 461,4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

/Хүснэгт №1/

		2011 онд	2012 онд	Бүгд
1.	Оюутны сургалтын төлбөр /1 жилд 500 мянган төгрөг, 2 жил олгосон/	66816,0	71148,6	137964,6
2.	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд /1 сая төгрөг/		318567,4	318567,4
3.	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлд	4858,3		4858,3
	<b>Нийт</b>	<b>71674,3</b>	<b>389716,0</b>	<b>461390,3</b>

Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 11-ний 181 дүгээр тогтоолын 3 дугаар заалтын дагуу хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлэхээр заасан нь олон нийтийн зүгээс хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлага, хүлээлтийг үүсгэх иргэд хувьцаагаа арилжаалах, өвлүүлэх, барьцаалах боломжгүй болгосон байна.

Төрийн залгамж чанар, бодлого алдагдсанаас болж “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч иргэд өнөөдрийг хүртэл хувьцааны үр шимийг хүртэх боломжгүй байсаар 4 жилийн нүүр үзэж байна. Тухайлбал, Засгийн газрын 2012 оны 116 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны 201 дүгээр тогтоолд заасны дагуу **1532853** иргэн 1072 ширхэг хувьцаагаа Засгийн газарт нэрлэсэн үнээр худалдах хүсэлт гаргасан байдалтай байна.

## **2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Сүүлийн үед үүсээд байгаа нөхцөл байдлаас хамаарч “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн иргэдийн эзэмшиж байгаа 1072 хувьцааг эргэлтэнд оруулах, хувь хэмжээг нь нэмэгдүүлэх, 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол улсын иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрт 1072 ширхэг хувьцааг шинээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт гаргасан хувьцааны төрийн эзэмшлийн хувьцаанаас **40 хүртэлх хувийг** 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол улсын иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрт хувь тэнцүүлэн нэмж эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах;

/Хүснэгт №2/

<b>№</b>	<b>Практикт хэрэгжих боломж</b>	<b>Төслийн сонгосон заалт</b>
1	Тогтоолын төслийн 1 дүгээр заалт	1/“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт гаргасан хувьцааны төрийн эзэмшлийн хувьцаанаас 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төрсөн Монгол улсын иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрт 1072 ширхэг хувьцааг шинээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах;
2	Тогтоолын төслийн 1 дүгээр заалт	2/Энэ тогтоолын 1.1 дэх дэд заалтад заасны дагуу иргэнд хувьцаа эзэмшүүлсний дараа “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нийт гаргасан хувьцааны төрийн эзэмшлийн хувьцаанаас 40 хүртэлх хувийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол улсын иргэний шинэчилсэн бүртгэлтэй иргэн бүрт

	хувь тэнцүүлэн нэмж эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах;
--	--

### 2.3.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг нээлттэй хувьцаат компани болгох, иргэдийн эзэмшиж байгаа хувьцааг бүртгэх ажлыг зохион байгуулах зохицуулалтыг тусгасан.

/Хүснэгт №3/

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Төслийн заалт
1	Тогтоолын төслийн 1 дүгээр заалт	3/“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг Компанийн тухай хуулийн 3.7-д заасан нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг хангуулж, төрийн болон иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах.

Монгол Улсын иргэнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт гаргасан хувьцааны төрийн эзэмшлийн хувьцаанаас 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төрсөн Монгол улсын иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэн бүрт 1072 ширхэг хувьцааг шинээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахаар тусгасан.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг бүртгэхдээ нэгдсэн бүртгэлийн дансанд бүртгэсний дараагаар хувьцаа эзэмшлийг төрийн мэдэл, нийт иргэдийн бүртгэл, шинэчилсэн бүртгэлд орсон иргэдийн бүртгэлийн дансанд тус тус хөтөлж байна.

Иргэдийн бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газар /хуучнаар/-аас шинэчилсэн бүртгэлд хамрагдсан Монгол улсын иргэдийн мэдээлэлд, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас хишиг, хувь хүртсэн иргэдийн мэдээллийг тус тус хүлээн авч харьцуулан тулгалт хийсний дараагаар нийт иргэдийн бүртгэлийн данснаас шинэчилсэн бүртгэлд орсон иргэдийн дансанд нийт дүнгээр зохих өөрчлөлтийг тухай бүр шилжүүлэн бүртгэх ажиллагаа хийдэг байна.

Аж ахуйн нэгжийн бүртгэлийг Татварын ерөнхий газраас ирүүлсэн хувьцаа худалдан авах шалгуур хангасан үндэсний аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалт болон хувьцаа худалдан авах захиалгын нэгдсэн мэдээллийг үндэслэн бүртгэлийг хийдэг.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 334 дүгээр тогтоолын дагуу хувьцаагаа зарах хүсэлт гаргасан 1 309 983 иргэн байгаа ба бэлэн мөнгө авсан 1 294 302 иргэний 360 438 096 340 төгрөгт ногдох 386 416 192 ширхэг хувьцааг төрийн мэдэлд шилжүүлжээ. Үүнээс:

№	Авсан мөнгө	Иргэдийн тоо	Нийт
1.	100,142.00	48,270	4,833,854,340.00
2.	200,284.00	187,096	37,472,335,264.00
3.	300,426.00	1,058,936	318,131,906,736.00
<b>Нийт</b>		<b>1,294,302</b>	<b>360,438,096,340.00</b>

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт 15 000 000 000 ширхэг хувьцаанаас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар хувьцааны эзэмшлийн бүртгэл дараах байдалтай байна. Үүнд:

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа эзэмшигч тоо	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн Хувь %/
Эрдэнэс Тавантолгой /ААН/	486	7,065,038	0.05
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	2,512,771	2,213,063,202	14.75
Эрдэнэс Тавантолгой /Эрдэнэс Монгол ХХК/	-	9,779,871,760	65.20
Эрдэнэс Тавантолгой /Гаргаагүй үлдэгдэл/	-	3,000,000,000	20.00

Дээрх иргэдээс 2022/04/11-ны өдрийн байдлаар Монгол улсын харьяатаас гарсан 13,365 иргэн, нас барсан 90,284 иргэн хувьцаа эзэмшиж байна.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2019 оны ногдол ашиг болох 179,830,170,360.00 төгрөгийг 2,512,768 иргэнд 179,257,902,282 төгрөг, 486 аж ахуйн нэгжид 572,268,078 төгрөг олгохоор байгаагаас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 2,171,215 иргэнд 154,765,768,176.00 төгрөг, 264 аж ахуй нэгжид 408,322,053.00 төгрөгийн ногдол ашгийг Төрийн сан дахь “ҮЦТХТ” ХХК-ийн данснаас иргэдийн баталгаажсан арилжааны банкны дансанд шилжүүлжээ.

Одоогийн байдлаар Монгол Улсад “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмших эрхтэй 3,306,052 иргэн байна.

Цаашид компанийн сайн засаглалыг хөгжүүлэх, өмчлөл, удирдлагын хяналтын тэнцвэртэй байдлыг хангах, компанийн хувьцааны эзэмшил, мэдээллийн ил тод, нээлттэй байдлаар дамжуулан олон нийтийн хяналтыг бий болгож, зах зээлд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэс

Тавантолгой" ХК-ийг Компанийн тухай хуулийн 3.7-д заасан нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байна.

Мөн сүүлийн үед үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг иргэдийн хяналтад оруулах, иргэдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хэмжээг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авах шаардлага үүсч байна.

Түүнчлэн 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төрсөн Монгол Улсын иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй иргэд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 1072 ширхэг хувьцааг эзэмшдэггүй тул төрийн эзэмшлийн хувьцаанаас шинээр эзэмшүүлэх болон Монгол Улсын иргэн бүрт хувь тэнцүүлэн нэмж эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж байгалийн баялгаас иргэн бүр тэгш хүртэх боломжийг олгох талаар тогтоолын төсөлд тусгалаа.

#### ТӨСӨЛ САНААЧЛАГЧ